



ХӨВСГӨЛ АЙМАГ  
ЦАГААН-ҮҮР СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ

2016 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 02

Булган

Сумын 2016 оны төсөвт тодотгол хийх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ийн “б” заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3, 34 дүгээр зүйлийн 34.2.2, 57 дугаар зүйлийн 57.3, 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын ээлжит бус XIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын ерөнхий орлогын дансны 2015 оны жилийн эцсийн үлдэгдэл 18417.1 мянган төгрөгийг тодотгон 1 дүгээр хавсралтанд заасны дагуу зарцуулсугай.

2. Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зйүлийн 18.1.2.-ын “в”, 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн “д” заалтууд хүчингүй болсонтой холбогдуулан уг арга хэмжээг хэрэгжүүлэх аймгийн Засаг даргын 2016 оын А/131 дүгээр захирамжийг үндэслэн "сум хөгжүүлэх сангийн дансыг хааж, үлдэгдэл 22664194 төгрөгийг сумын төсвийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсүгэй.

3. Орон нутгийн төсвийн байгууллагуудын төсөвт хийх тодотголыг 2 дугаар хавсралтаар, төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээ, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо, хэмжээний үзүүлэлтийг 3 дугаар хавсралтаар, сумын ЗДТГ-ын төсөвт хөтөлбөр болгон орлого, зарлагыг тооцож сүм хөгжүүлэх сангийн 2016 оны төсвийг тодотгон зарцуулах хуваарийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

4. Сумын 2015 оны орон нутгийн төсвийн орлого, орон нутгийн төсвийн байгууллагуудаас төвлөрүүлсэн дансны үлдэгдэл 18417.1 мянган

төгрөгийг 2015 оны зарцуулалтын эрхийн хязгаарлалт болон санхүүжилт дутуу ирсэнтэй холбоотойгоор үүссэн өрийг барагдуулах, 2016 оны төсвийн дутагдалтай байгаа зардлын зүйлийг санхүүжүүлэх байдлаар үр дүнтэй зарцуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, Төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

5. Сумын ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 04 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтын 1.1.2-т заасан эрчим хүчний өргөтгөл 25.0 сая төгрөгийг өнгөрсөн жилийн эрчим хүчний өргөтгөлийн ажлын санхүүжилт болгож нэршлийг өөрчлөн баталсугай.


6. Сум хөгжүүлэх санг орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгосонтой холбогдуулан хөрөнгийн зарцуулалт, зээл олголт, зээлийн хүүгийн барагдуулалтыг сайжруулах талаар арга хэмжээ авах, төсөл сонгон шалгаруулах журмыг хуульд нийцүүлэн боловсруулж, үйл ажиллагаандaa хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга Т.Ханддорж, ЗДТГ-ын дарга Д.Цогт-Эрдэнэ нар үүрэг болгосугай.

7. Төсвийн тодотголыг холбогдох байгууллагуудын 2016 оны төсөвт тусган, сарын хуваарьт өөрчлөлт оруулан, мөрдөн ажиллахыг сумын Засаг дарга /Т.Ханддорж/-д зөвшөөрсүгэй.

8. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга /О.Үүрийнбаяр/-т үүрэг болгосугай.



Цагаан-Үүр сумын ИТХ-ын ээлжит бус XIII  
хуралдааны 2016 оны 04 дүгээр сарын 26-ны  
өдрийн 02 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



**СУМЫН 2015 ОНЫ ЕРӨНХИЙ ОРЛОГЫН  
ДАНСНЫ ҮЛДЭГДЛИЙГ ЗАРЦУУЛАХ ХУВААРИЛАЛТ**

мян. төгрөгөөр

| №                            | Эх үүсвэр   |  | Дүн            |
|------------------------------|---|--|----------------|
| 1.                           | Сумын орон нутгийн ерөнхий орлогын дансны нийт үлдэгдэл |  | 18417.1        |
| <b>Нийт эх үүсвэрийн дүн</b> |   |  | <b>18417.1</b> |
| 1.1                          | Үүнээс  | Сумын ОНХС-ийн 2016 оны эх үүсвэр болгох.  | 714.0          |
| 1.2                          |   | ЗДТГ-ын 2015 оны зарцуулалтын эрхийн хязгаарлалт болон санхүүжилт дутуу ирсэнтэй холбоотойгоор үүссэн өрийг барагдуулах, 2016 оны төсвийн дутагдалтай байгаа зардлын зүйлийг санхүүжүүлэх. | 16326.4        |
| 1.3                          |   | ИТХ-ын "2015 оны зарцуулалтын эрхийн хязгаарлалт болон санхүүжилт дутуу ирсэнтэй холбоотойгоор үүссэн өрийг барагдуулах, 2016 оны төсвийн дутагдалтай байгаа зардлын зүйлийг санхүүжүүлэх. | 1376.7         |
| <b>Нийт зарлагын дүн</b>     |   |  | <b>18417.1</b> |

-----оо-----

Цагаан-Үүр сумын ИТХ-ын ээлжит бус XIII  
хуралдааны 2016 оны 04 дүгээр сарын 26-ны  
өдрийн 02 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРИМ  
БАЙГУУЛЛАГЫН ТӨСӨВТ ХИЙХ НЭМЭХ ТОДОТГОЛ**

мян.төгрөгөөр

| Зардлынзүйл                   | ЗДТГ            | ИТХ             | ОН<br>байгууллага<br>дүн |
|-------------------------------|-----------------|-----------------|--------------------------|
|                               | Нэмэгдэх<br>дүн | Нэмэгдэх<br>дүн |                          |
| Цалин, нэмэгдэл урамшуулал    | 3109.9          |                 | 3109.9                   |
| Үндсэнцалин                   | 2552.7          |                 | 2552.7                   |
| Гэрээтийн цалин               |                 |                 |                          |
| Урамшуулал                    |                 |                 |                          |
| Унаахоол                      |                 |                 |                          |
| <b>НД-ыншиимтгэл</b>          | <b>557.2</b>    |                 | <b>557.2</b>             |
| <b>Тогтмолзардал</b>          |                 |                 |                          |
| Гэрэлцахилгаан                |                 |                 |                          |
| Түлшхалаалт                   |                 |                 |                          |
| Цэвэрбохирус                  |                 |                 |                          |
| Байрнытуруээс                 |                 |                 |                          |
| <b>Хангамж бараа материал</b> | <b>7592.5</b>   | <b>772.6</b>    | <b>8365.1</b>            |
| Бичигхэрэг                    | 2292.5          |                 | 2292.5                   |
| Тээвэршатахуун                | 5300.0          | 600.0           | 5900.0                   |
| Шууданхолбоо                  |                 |                 |                          |
| Ном хэвлэл                    |                 | 152.7           | 672.7                    |
| БҮТЭЗҮЙЛ                      |                 |                 |                          |
| Хог хаягдал зайлзулах         |                 |                 |                          |
| <b>Нормативт зардал</b>       |                 |                 |                          |
| Нормынхувцас, зөөлөнэдлэл     |                 |                 |                          |

|  |                |               |                |
|--|----------------|---------------|----------------|
| <b>Эд хогшил урсгал засварын зардал</b>        | <b>3240.0</b>  |               | <b>3240.0</b>  |
| Багаж, хэрэгсэл                                |                |               |                |
| Урсгал засвар                                  | 3240.0         |               | 3240.0         |
| <b>Томилолт, зочны зардал</b>                  | <b>0.0</b>     | <b>150.0</b>  | <b>150.0</b>   |
| Дотоод албан томилолт                          |                | 150.0         | 150.0          |
| <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын төлбөр</b>      | <b>1534.0</b>  |               | <b>1534.0</b>  |
| Байгаль орчин нөхөн сэргээх                    | 1534.0         |               | 1534.0         |
| Мэдээлэл технологи                             |                |               |                |
| Өвс тэжээлийн нөөц                             |                |               |                |
| Эрчимжсэн мал ААХөгжүүлэх                      |                |               |                |
| Хүнс барааны нөөц                              |                |               |                |
| Хувцасны нөөц                                  |                |               |                |
| Шатахууны нөөц                                 |                |               |                |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр |                |               |                |
| <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>         | <b>850.0</b>   | <b>0.0</b>    | <b>850.0</b>   |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага                   |                |               |                |
| Биеийн тамирын уралдаан тэмцээн                | 850.0          |               | 850.0          |
| Орон нутгийн нөөц                              |                |               |                |
| <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                  | <b>0.0</b>     | <b>474.0</b>  | <b>474.0</b>   |
| Тэтгэвэрт гарахад нь олгох тэтгэмж             |                |               |                |
| Нэг удаагийн шагнал                            | 0.0            | 474.0         | 474.0          |
| <b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>                       | <b>16326.4</b> | <b>1376.7</b> | <b>17703.1</b> |
| <b>САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                  | <b>16326.4</b> | <b>1376.7</b> | <b>17703.1</b> |
| Санхүүдэмжлэг                                  |                |               |                |
| Аймгийнорлого                                  |                |               |                |
| Сумынорлого                                    |                |               |                |
| <b>2015 оны дансны үлдэгдэлээс</b>             | <b>16326.4</b> | <b>1376.7</b> | <b>17703.1</b> |

-----ооо-----

Цагаан-Үүр сумын ИТХ-ийн ээлжит бус XIII  
хуралдааны 2016 оны 04 дүгээр сарын 26-ны  
өдрийн 02 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ ТОО  
БОЛОН ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ**


| <b>№</b> | <b>ТЕЗ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР,<br/>ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b> |   | <b>2016 ОНЫ<br/>ЗОРИЛТОТ<br/>ТҮВШИН</b>                                     |
|----------|--|---|---|
| 1.       | <b>Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга</b>                                   |   |   |
|          | 1.1  | <b>Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа</b>   |   |
|          | 1.1.1  | Нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлж, түүний хэрэгжилтийг хангаж, тэргүүлэгчдийн хуралдааныг товлож, хэлэлцэх асуудлыг оруулж, хэлэлцүүлж гарсан шийдвэрийг байгууллагуудад танилцуулах, Засгын газраас болон аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл явцын талаар болон түүний биелэлтийн талаарх тайлан мэдээллийг ИТХ-ын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх | Төлөвлөгөөт ажил бүрэн биелэсэн байх. Зарцуулах төсөв 38794.6 мянган төгрөг |
|          | 1.2  | <b>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх</b>   |   |
|          | 1.2.1.   | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах, гэмт хэргийн гаралтыг бууруулах.  | Зарцуулах төсөв 1200.0 мянган төгрөг  |

|    |  |  |   |
|----|--|--|---|
| 2. | <b>Сумын Засаг дарга</b>                               |  |   |
|    | <b>2.1 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага</b> |  |   |
|    | 2.1.1  | Zасгийн газрын болон аймгийн Засаг дарга, ИТХ-аас гаргасан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх боловсруулах, хуралдаанд бэлтгэх болон сум, хэлтэс агентлагийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, Сумдын Засаг даргын тамгын газрын ажилтнууд болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргыг нутгийн удирдлагын чиглэлээр мэргэжлийн, зөвлөгөө өгч сургалт семинарыг зохион байгуулж, мэдээллээр хангасан байх | Ажлын үр дүн сайжирсан байх Зарцуулах төсөв 249227.2 мянган төгрөг  |
|    | 2.1.2  | Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэр, Монгол улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Хөтөлбөр, төслийн мэдээллэл, үйл ажиллагааны үр дүнгийн мэдээллийг графикт хугацаанд гаргаж холбогдох газарт хүргүүлж мэдээлж байх   | Төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжсэн байх.                               |
|    | <b>2.2 Биологийн төрөл зүйлийн хамгаалалт</b>          |  |   |
|    | 2.2.1  | Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх ажил үйлчилгээг улам чанаржуулж, үр дүнг ахиулах  | Төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжинэ. Төсөв төгрөг 20044.4 мянган төгрөг |

|  |        |  |  |   |
|--|--------|--|--|---|
|  | 2.3    | <b>Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт</b>  |  |   |
|  | 2.3.1. | ОНХС-ийн хэрэнгээр төлөвлөн баталсан ажил үйлчилгээнүүдийг бүрэн, чанартай хийж гүйцэтгэх, аймаг орон нутгийн хөгжилд зохих хувь нэмрийг оруулах | хэрэнгээр<br>бүрэн, чанартай хийж гүйцэтгэх, аймаг орон нутгийн хөгжилд зохих хувь нэмрийг оруулах | Төлөвлөгөөт ажил үйлчилгээнүүд бүрэн хэрэгжсэн байх. Төсөв 123729.8 мянган төгрөг |
|  | 2.1    | <b>Ангилагдаагүй бусад</b>   |  |   |
|  |        |  |  |   |

-----oOo-----

Цагаан-Үүр сумын ИТХ-ын ээлжит бус XIII  
хуралдааны 2016 оны 04 дүгээр сарын 26-ны  
өдрийн 02 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт



**СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН 2016 ОНЫ ТОДОТГОСОН ТӨСӨВ**

**МЯН.ТӨГРӨГӨӨР**

| <b>Зардлын зүйл</b>  | <b>Дүн</b>      |
|--|-----------------|
| <b>Зээлийн эргэн төлөлтөөс орох орлого</b>   | <b>137418.0</b> |
| <b>Зээлийн хүүгийн орлого</b>  | <b>7494.3</b>   |
| <b>Алданги</b>   | <b>7455.6</b>   |
| <b>ОРЛОГЫН ДҮН</b>   | <b>152367.9</b> |
| Шуудан холбооны зардал /сард-20.0/   | 240.0           |
| Бичиг хэрэг  | 200.0           |
| Ном хэвлэл /зээлдэгчдийн төсөл<br>хөтөлбөрийн хэрэгжилтийг ард иргэдэд<br>мэдээлэх сонин хэвлүүлбэхэд/ | 500.0           |
| Урамшуулал/ комисс гишүүд/   | 910.0           |
| Тээвэр шатахуун/Хяналт хийхэд/   | 1500.0          |
| Зээлдэгчдийн өдөрлөг зохион байгуулах,<br>Мэдээлэл сурталчилгаа хийх                                   | 350.0           |
| <b>ЗЭЭЛ ОЛГОЛТ</b>   | <b>148667.9</b> |
| <b>ЗАРДЛЫН ДҮН</b>   | <b>152367.9</b> |